

УЛС ТӨР, ОЛОН
УЛСЫН ХАРИЛЦАА

**БҮГД НАЙРАМДАХ
АРДЧИЛСАН АФГАНИСТАН
УЛСЫН ГАДААД БОДЛОГО**

М. ХУРМЕТХАН

1978 оны 4-р сард Афганистанд ялсан үндэсний ардчилсан хувьсгал нь тус орны түүхэнд чанарын шинэ үе нээж Афганистаны нийгэм-эдийн засгийн бодлогод төдийгүй гадаад бодлогод үндсэн өөрчлөлт хийсэн билээ. Дөрөвдүгээр сарын хувьсгалын өмнө Афганистаны гадаад бодлого нь голдуу империалистууд ба олон улсын харгис хүчинтэй нягт холбоотой байсан цөөн тооны дарлагч ангийн эрх ашгийг үндэс болгон явагдаж байлаа. Дөрөвдүгээр сарын хувьсгал, ялангуяа түүний шинэ шатны дараа ЕНААфгУ-ын гадаад бодлого нь ажилчин ангийн эрхэм дээд зорилго, Афганистаны нийгмийн хөгжлийн өнөө үеийн шаардлагыг үндэслэн явагдаж байна. Энэхүү гадаад бодлого нь нийгэм-ангийн агуулгын үүднээс авч үзвэл Дөрөвдүгээр сарын хувьсгалын зорилтыг хэрэгжүүлэх хэрэгсэл болж байна. Тэрчилэн олон улсын тавцан дээр Афганы ард, түмний язгуур эрх ашгийг тусган илэрхийлж байгаа билээ. Тус улсын гадаад бодлогын үндсэн зарчмуудыг «БНААфгУ-ын үндсэн зарчмууд», Афганистаны Ардын Ардчилсан намын үйл ажиллагааны программ»-д тодорхойлон заасан юм.¹

АААН, Хувьсгалт Зөвлөл, БНААфгУ-ын засгийн газар, энх тайвны нөхцөлд хүн хүч болон байгалийн нөөцийг шинэ амьдралыг бүтээн байгуулах үйлсэд чиглүүлж байж л афганы ард түмнийг нийгэм-эдийн засгийн дэвшлийн замд оруулж болох юм гэж бүр эхнээсээ үзэж байлаа. Ийм учраас Афганы ард түмний энх амгалан амьдралын гадаад таатай нөхцөлийг хангахад бүс нутгийн энх тайвныг бэхжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, улсын ашиг сонирхлыг хамгаалах чиглэлийг БНААфгУ гадаад бодлогынхоо үйл ажиллагааны үндэс болгон баталсан

БНААфгУ, энхийг эрхэмлэгч улсын хувьд бусад улс оронтой ялангуяа хөрш бүх лалын шашинт улс, ард түмэнтэй харилцан бие биенээ хүндэтгэх, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, аль алиныхаа дотоод хэрэгт үл оролцох үндсэн дээр найрамдалт харилцаатай байхыг эрхэмлэдэг. 1982 оны 3-р сард хуралдсан АААН-ын нийт үндэсний бага хурлаар батлагдсан «АААН-ын үйл ажиллагааны программ»-д гадаад бодлогын үндсэн зорилтуудыг тодорхойлон заасан билээ. Үүнд:

— Нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, бүрэн эрхт байдал, үндсэний тусгаар тогтнолыг хамгаалах,

--Дарлагч анги ба урвагч нарын харгис засгийн газраас үлдсэн хор уршгийг устгах, Афганистаны эсрэг империализм ба харгис хүчний явуулж байгаа зарлаагүй дайныг эцэс болгох, дөрөвдүгээр сарын хувьсгалын зорилтуудыг биелүүлэхэд бүтээлч үйл ажиллагаа явуулахын тулд энх тайван байдал тогтооход олон улсын тааламжтай нөхцлийг бүрэлдүүлэх;

¹ Whitebook. Foreign Policy Documents of the Democratic Republic of Afghanistan, Kabul, 1982, p. 12.

— Афганистаны олон улсын байр суурийг бэхжүүлэх, хөгжил дэвшлийн зайлшгүй чухал нөхцлийг бүрэлдүүлэхийн тулд ЗХУ ба социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай улс төр, эдийн засаг, худалдаа, соёл шинжлэх ухаан, техник болон бусад салбарт ах дүүгийн найрамдалт харилцаа, уламжлалт хамтын ажиллагааг тогтоон хөгжүүлэх;

— НҮБ-ын дүрэм, зарчмыг хэлбэрэлтгүй хүндэтгэн, нягт чанд сахин мөрдөх;

— Энх тайван, олон улсын намжмал байдал тогтоох, зэвсэг хураах, Цөмийн зэвсгийг хориглох ба хураах, ард түмнүүдийн найрамдал, эрх чөлөө, ардчилал, нийгмийн дэвшил, хүний эрхийг хамгаалахын төлөө империализм, жанжлал, арьсны үзэл, сионизм, апартейд, колончилал, шинэ колончлолын эсрэг тэмцэлд Афганистаны хөдөлмөрч ард түмэн ба дэлхийн улс түмний нэгдэл нягтрал, эв санааны нэгдлийг бэхжүүлэх,

— Эвсэлд үл нэгдэх бодлого явуулан дэвшилт бүх улс орон, олон улсын байгууллагатай найрамдалт харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх;

— Улс төр, нийгмийн байгууллыг үл харгалзан үндэсний бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, тэгш эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, бие биенийхээ дотоод хэрэгт үл оролцох зарчмыг баримтлан дэлхийн бүх улс оронтой найрамдалт харилцаагаа хөгжүүлэх явдал юм² гэж баримт бичиг тодорхойлон заасан байна.

БНААфГУ-ын гадаад бодлогын зарчим, чиг шугам нь социалист хамтын нөхөрлөлийн орнуудын гадаад бодлоготой бүрэн нийцэж байна. АААН, БНААфГУ-ын засгийн газар, социалист хамтын нөхөрлөлийн орнуудын нам, засгийн газар, ард түмэнтэй ах дүүгийн хэлхээ холбоогоо өргөжүүлэн гүнзгийрүүлэхийг онцгой чухал ач холбогдолтойд үзэг, шинэ нийгмийн байгуулалтад олж байгаа амжилтыг өндөр үнэлж байна.

«АААН социалист хамтын нөхөрлөлийн орнуудын Коммунист, ажилчны намууд, ард түмэнтэй, эвсэлд нэгдээгүй орнуудтай, энх тайван, хүн төрөлхтний дэвшлийн төлөө тэмцэж байгаа бүх нам, байгууллагатай хамтын ажиллагаагаа байнга бэхжүүлэх болно³ гэж АААН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Нажиб мэдэгдсэн билээ.

БНААфгу гадаад бодлогодоо, давын өмнө ЗХУ, социалист хамтын Нөхөрлөлийн бусад орнуудтай тогтоосон найрамдал, ах дүүгийн харилцааны хүрээнд, тэрчилэн АААН-аас манай эрин үеийн бусад хувьсгал хүчинтэй тогтоосон олон талт үр ашигтай холбооны хүрээнд үйлчилдэг Интернационалч эв санааны нэгдлийн зарчмыг удирдлага болгодог. Энэ хүү харилцааны бэхжилт, цаашдын хөгжил нь Афганы ард түмний үндэсний язгуур эрх ашигт бүрэн нийцэж, БНААфГУ-ын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, олон улсын байр суурийг бэхжүүлэхэд ихээхэн тус дөхөм болж байна.

БНААфГУ, ЗХУ-ын хоорондын сайн хөршийн харилцаа, ах дүүгийн найрамдал, хувьсгалч эв санааны нэгдэл нь үүнд онцгой чухал үүрэг гүйцэтгэж байна. АААН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Нажиб хэлэхдээ: «Аугаа их Зөвлөлт Холбоот Улс, их Лениний нам, Зөвлөлтийн тусч, баатарлаг ард түмэнтэй тогтоосон найрамдлаа улам бэхжүүлэн бататгах явдал бүхий л ажлын үндэс байх болно»⁴ гэжээ.

² «Хакикате инклабе саур» 1982. № 222.

³ «Үнэн» 1986. 5. 6.

⁴ Мөн тэнд

Агуу их ЗХУ-тай БНААфГУ-ын байгуулсан ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааг цаашид бэхжүүлэх нь Афганистаны эрх чөлөө, тусгаар тогтнол, хөгжил цэцэглэлтийн найдвартай баталгаа гэж ААН, Хувьсгалт Засгийн газар зүй ёсоор үздэг юм. 1919 онд английн колоничлолоос чөлөөлөгдөж, тусгаар тогтнолоо дөнгөж олсон Афганистаныг анх түрүүн хүлээн зөвшөөрч, найрсаг харилцаа тогтоосон улс бол залуу Зөвлөлт Орос бөгөөд ингэж Зөвлөлт, Афганистаны ард түмний сайн хөршийн харилцаа, найрамдлын эх суурь бүр Зөвлөлт засгийн анхны жилүүдэд В. И. Лениний шууд оролцоотойгоор тавигдсан билээ.

Афганистанд дөрөвдүгээр сарын хувьсгал ялсны дараа тус хоёр орны харилцаа зарчмын шинэ шатанд гарч 1978 оны 12-р сарын 5-нд гарын үсэг зурсан ЗСБНХУ, БНААфГУ-ын хоорондын найрамдал, сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээгээр бататгагдсан юм. Уг гэрээнд хоёр орны хоорондын найрамдал бүх талын хамтын ажиллагааг бүх талаар бэхжүүлэх, зөвлөлт-афганы ард түмнүүдийн нийгэм эдийн засгийн ололтуудыг хөгжүүлэх, тэдний аюулгүй байдал, тусгаар тогтнолыг хамгаалах, энх тайван, үндэснийхээ эрх чөлөө, ардчилал болон нийгмийн дэвшилтийн төлөө тэмцэгч хүчнүүдийн эв санааны нэгдлийн төлөө тууштай тэмцэх, Ази тив болон даян дэлхийд тайван аюулгүй байдлыг бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлэхэд хувь нэмэр оруулах талаар тодорхой заажээ.

ЗХУ, БНААфГУ-ын хоорондын хамтын ажиллагаа амьдралын бүх салбарт амжилттай хөгжиж байгааг 1980 оны 10-р сард ЗХУ-д хийсэн афганы удирдагчдын албан ёсны нөхөрсөг айлчлалынхаа явцад онцлон тэмдэглэсэн юм. Афганистаны ард түмний тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлаа хамгаалахад ЗХУ ямагт дэмжлэг тусламж үзүүлж Ирсэн түүхтэй.

Афганистанд эдийн засгийн хөгжлийн үндсэн асуудлыг шийдвэрлэхэд ЗХУ-ын үзүүлж буй тусламж асар их үүрэг гүйцэтгэж байна. Афганистаны аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 60 орчим хувийг Афган-Зөвлөлтийн хамтын ажиллагааны үрээр боссон барилга байгууламж дээр үйлдвэрлэж байгааг дурдахад хангалттай. Мөн ЗХУ-аас тус оронд соёл, шинжлэх ухаан, боловсролыг хөгжүүлж, үндэсний сэхээтнийг бэлтгэх талаар үзүүлсэн үнэлж баршгүй тусламжийг Афганистанд өндрөөр үнэлдэг.

1979 оны сүүлчээр БНААфГУ-ын засгийн газрын удаа дараагийн хүсэлтийн хариуд империалистуудын зэвсэгт түрэмгийллийг няцаахад афганы ард түмэнд туслахаар ЗХУ цөөн тооны цэргээ Афганистанд илгээсэн билээ. ЗХУ-ын энэхүү интернационалч тусламжийг талархан: «Бидний хамгийн хүнд өдрүүдэд Зөвлөлт Холбоот Улс хосгүй интернационалч тусламж үзүүлснийг бид онцгой талархан тэмдэглэж байна. ЗХУ-ын баатарлаг хөвгүүд манай орны тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдлыг хамгаалж, дөрөвдүгээр сарын хувьсгалыг хамгаалахад афганы ард түмэнд туслахаар хүрэлцэн ирсэн юм»⁵ гэж БНААфГУ-ын Хувьсгалт Зөвлөлийн дарга Бабрак Кармаль онцлон тэмдэглэсэн юм.

БНААфГУ-ын нам, төрийн удирдагчид янз бүрийн салбар дахь

⁵ 20-летие Народно демократической партий Афганистана (Материалы юбилей-ного заседания ЦК НДПА, Революционного совета и Совета Министров ДРА, Кабул, 1985, с. 33–34.

Зөвлөлт-Афганы хамтын ажиллагааны мөн чанар, утга зорилгыг гуйвуулагчдад шийдвэртэй няцаалт өгч байна. АААН-ын 20 жилийн ойд зориулсан ойн хурал дээр «Империалист суртал нэвтрүүлэгчид «Афганистаныг Зөвлөлт улс эзэгнэж байгаа» мэтээр дэлхий дахинд хашгичаж байна. Тэгвэл Зөвлөлтийн ах дүүс бидний уриалгыг хүлээн авч, амь насаа ч үл хайрлан ийм тусламж үзүүлж байна гэж дэлхий дахинд бид хэлэх байна. Зөвлөлтийн ах дүүсийн нэр алдар бадартугай»⁶ гэж ЗХУ-ын интернационалч тусламжийг өндрөөр үнэлэн бахархан тэмдэглэсэн билээ.

БНААфГУ-социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой улс төр, эдийн засаг, соёлын талбарт найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг улам өргөжүүлэн байна.« Шинэ Афганистаныг цогцлон байгуулах үйл хэрэгт социалист хамтын нөхөрлөлийн орнууд үнэт хувь нэмэр оруулж, дөрөвдүгээр сарын хувьсгалыг дэмжиж байгааг бид сэтгэл ханамжтай тэмдэглэж байна. Эдгээр орны засгийн эрх барьж байгаа нам, засгийн газар, ард түмэнтэй ах дүүгийн харилцаагаа улам өргөжүүлэн гүнзгийрүүлэхийг АААН, БНААфГУ-ын засгийн газар, афганы ард түмэн онцгой чухал ач холбогдолтойд үзэж байна»⁷ гэж афганы удирдагчид тэмдэглэсэн билээ. Афганистаны нам, төрийн төлөөлөгчид БНСЧСУ, БНБАУ, БНАГУ, БНУАУ, БНМАУ-д албан ёсны найрсаг айлчлал хийж, найрамдал, хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр байгуулснаар тэдгээр оронтой хамтын ажиллагаа хөгжүүлэх сайхан боломж нээгдсэн юм.

Нийгмийн хөгжил дэвшлийн төлөө нийтлэг зорилгод чиглэсэн МАХН, АААН-ын зарчимч чиг шугам монгол, афганы ард түмнээс ЗХУ ба ах дүү социалист бусад оронтой байгуулсан найрамдал, интернационалч эв санааны нэгдэл нь монгол-афганы бүх талын хэлхээ холбоог хөгжүүлэх найдвартай үндэс суурь болж байна. БНМАУ, БНААфгу-ын хооронд найрамдал хамтын ажиллагааны тухай гэрээ байгуулагдсан нь МАХН, АААН болон БНМАУ, БНААфГУ-ын харилцааг шинэ дээд шатанд гарган, хоёр орны ард түмний ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэх хэтийн төлөвийг нээж өгсөн юм.

Манай нам, засгийн газар БНААфГУ-ын гадаад бодлогыг өндөр үнэлэн, сайшаан дэмждэг билээ. Афганистаны ард түмний үндэсний баяр Дөрөвдүгээр сарын хувьсгалын долоон жилийн ойд зориулан МАХН ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ж. Батмөнх, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга нөхөр Д. Содном нараас АААН-ын Төв Хороо ны ерөнхий нарийн бичгийн дарга, БНААфГУ-ын Хувьсгалт Зөвлөлийн дарга, БНААфГУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга нарт явуулсан баярын мэндчилгээнд «БНМАУ, энхийг эрхэмлэгч бүх улс орны хамт улс түмний энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад чиглэсэн БНААфГУ-ын Засгийн газрын үйл ажиллагааг өндрөөр үнэлдэг бөгөөд Афганистаны эргэн тойронд бий болсон түгшүүртэй байдлыг эв зүйгээр зохицуулах зорилгоор түүний дэвшүүлсэн оновчтой санал, санаачилгуудыг бүрэн дүүрэн дэмжиж байна»⁸ гэсэн билээ.

⁶ 20-летие Народно-Демократической Партий Афганистана (Маториалы юбилейного заседания ЦК НДПА, Революционного Совета и Совета Министров ДРА Кабул, 1985.

⁷ Мөн тэнд 34-р тал.

⁸ «Үнэн» 1985.4, 27.

Афганистан улсын эвсэлд үл нэгдэх идэвхтэй бөгөөд тууштай гадаад, бодлого нь империализм, колоницлол, шинэ колоницлолын эсрэг эрх чөлөө, тусгаар тогтнол, нийгмийн хөгжлийн төлөө бүх улс түмний тэмцлийг идэвхтэй дэмжихэд чиглэгдэж байна.

1983 оны 3-р сарын 7—11-нд Шинэ Дели хотод болсон эвсэлд нэгдээгүй орнуудын төр, засгийн газрын тэргүүн нарын бага хурал дээр БНААфгУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга С. А. Кештманд хэлсэн үгэндээ: «Афганистаны засгийн газар нь өөрийн орны дотоод бодлоготой бүрэн нийцүүлэн дэлхийн бүх орнуудтай тогтоосон харилцаандаа тууштай зарчимч замаар явж байна. Афганистан улс нь эвсэлд нэгдээгүй улс байсан бөгөөд байх ч болно. Бид идэвхтэй ба тууштай эвсэлд үл нэгдэх, Энх тайвнаар зэрэгцэн орших зарчим, зэвсгээр хөөцөлдөхийг зогсоож, зэвсгийг бүх нийтээр хураах бодлогыг тууштай дэмжиж байна. Энх тайвныг эрхэмлэх хүчинтэй хамтаар дайн дэгдээгчид, империализм шинэ Колоницлол, сионизм, фашизм, арьсны үзэл, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл, апартейдын эсрэг тэмцэх болно»⁹ гэж тэмдэглэсэн билээ.

БНААфгУ-нь НҮБ-ыг олон улсын энх тайван, аюулгүй байдал болон олон чухал асуудлуудыг зохицуулахад дөхөм үзүүлэх үр ашигтай байгууллага гэж үздэг бөгөөд түүний бүх нийтийн бат бэх энх тайвныг бэхжүүлэхэд чиглэсэн бүхий л үйл ажиллагаанд тус дөхөм үзүүлэхийг эрмэлздэг. Дөрөвдүгээр сарын хувьсгалаас хойш НҮБ-д БНААфгУ-ын гүйцэтгэж байгаа үүрэг улам дээшлэв.

«Үндсэн зарчим»-уудын 16-р зүйлд БНААфгУ нь НҮБ-ийн дүрэм, олон улсын эрхийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг сахин мөрдөж олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн НҮБ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийг заасан юм. Энэхүү заалтыг удирдлага болгон БНААфгУ нь НҮБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна.

БНААфгУ-ын засгийн газар нь Афганистаныг тойрон буй болсон асуудлыг улс төрийн аргаар шийдвэрлэхийн төлөө цуцалтгүй тэмцсээр байна. Энэ зорилгоор дэвшүүлсэн БНААфгУ-ын засгийн газрын 1980 оны 5-р сарын 14, 1981 оны 8-р сарын 24-ны санал, хөтөлбөрүүдийн үзэл санааг ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад орнууд бүрэн дүүрэн дэмжсэн юм. БНААфгУ-ын энэ санал нь олон улсын өргөн дэмжлэг олж, Пакистан, Ирантай БНААфгУ-ын харилцааг зохицуулах, энэ бүс нутгийн нөхцөл байдлыг хэвийн болгох замыг нээсэн үйл явдал болсныг социалист хамтын нөхөрлөлийн орнууд, дэлхийн олон нийт талархан дэмжсэн юм.

БНААфгУ-Ази тивийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн орнуудын хамтаар гуйвалтгүй чармайж, Энэтхэг-Хятадын хойгийн орнууд болон АСЕАН-ы гишүүн орнуудын харилцааг хэвийн болгох талаар Вьетнам, Лаос, Кампучийн ард түмэнтэй эв санаагаа нэгтгэн энхийг эрхэмлэгч бүх улс түмний хамт нэг эгнээнд тэмцэж байна.

⁹ Achievements of the april revolution in Afghanistan. Kabul. 1982, p. 29.